

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

(Хамрах хугацаа: 2023.12.13-2024.06.27)

2024.06.27.

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлөөс 2024 оны эхний хагас жилийн дүнгээр гүйцэтгэсэн ажлын товч тайланг танилцуулж байна.

Нэг. Сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгын талаар:

Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд 1 дүгээр улирлын дүнгээр салбар зөвлөлөөс төрийн захиргааны удирдах 1, гүйцэтгэх 7 албан тушаалын сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газарт албан бичгээр хүргүүлж, ажлын 10 хоног Төрийн албаны зөвлөлийн цахим сайтаар нийтэд зарлууллаа.

Хүснэгт-1

№	Захиалга хүргүүлсэн албан бичгийн огноо, дугаар	Сул орон тоо		Албан тушаалын нэр
		Удирдах албан тушаал	Гүйцэтгэх албан тушаал	
1	2024.01.24 №01	1	3	Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн дарга- 1; Зүүн бүс дэх газрын мэргэжилтэн-3.
2	2024.03.13 №02		4	Өмнөд бүс дэх газрын мэргэжилтэн-1; Зүүн бүс дэх газрын мэргэжилтэн-3.
ДҮН		1	7	

Төрийн албаны тухай хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн холбогдох заалт, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам, загвар батлах тухай” 25 дугаар тогтоолоор баталсан журмын 4.2-т заасныг хэрэгжүүлж, байгууллагын immigration.gov.mn цахим хуудсанд “Сонгон шалгаруулалтын зар” цэс, зарын дагуу төрийн жинхэнэ албан хаагчдаас баримт бичиг хүлээн авах shalgalt@immigration.gov.mn цахим хаягийг ажиллуулж, Төрийн албаны зөвлөлийн цахим системээс шууд шилжих боломжийг бүрдүүлсэн.

Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд эхний хагас жилийн дүнгээр салбар зөвлөлөөс 2 удаа удирдах 1, гүйцэтгэх 7 албан тушаалын сонгон шалгаруулалтын зарыг төрийн жинхэнэ албан хаагчдын хүрээнд 5-аас доошгүй хоног байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудсаар “Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах зар”-ыг нээлттэй байршуулж, нөхөгдөөгүй сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газарт албан бичгээр хүргүүлсэн.

Дээрх 2 удаагийн зарын дагуу 7 иргэн shalgalt@immigration.gov.mn цахим хаягаар Захиргаа, удирдлагын газарт нийслэлийн Газар, зохион байгуулалтын албанаас төрийн захиргааны дэс түшмэлийн 1, Дорноговь аймаг дахь газарт төрийн тусгай байгууллагын дэс түшмэлийн албан тушаалд адилтгах 1, Баруун бүс дэх

газарт Увс аймаг дахь хэлтсээс төрийн жинхэнэ албан хаагч 1, Баян-Өлгий аймаг дахь хэлтэст төрийн тусгай байгууллагын дэс түшмэлийн албан тушаалд адилтгах 1, нийт 4 мэргэжилтний албан тушаалд хүсэлт ирүүлсэн. Үүнээс тухайн албан тушаалын тодорхойлолт болон шаардлага хангасан 2 төрийн жинхэнэ албан хаагчийг Захиргаа, удирдлагын газарт хуулийн мэргэжилтэн, Баруун бүс дэх газарт мэргэжилтнээр тус тус шилжүүлэн ажиллуулахаар шийдвэрлэсэн.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд салбар зөвлөлийн 01, 06, 11 дүгээр тогтоолоор байгуулсан сонгон шалгаруулалт зохион байгуулах тусгай шалгалтын комисс байгуулж, төрийн захиргааны удирдах 1, гүйцэтгэх 9 албан тушаалын сул орон тоо нөхөх 3 удаагийн тусгай шалгалтыг зохион байгууллаа. Тусгай шалгалтад тэнцсэн иргэдийн 6 буюу 60.0 хувь нь 2021-2024 оны төрийн албаны ерөнхий шалгалтын нөөцөд бүртгэлтэй иргэд, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн иргэн 1 буюу 10 хувь, 2 буюу 20 хувь төрийн жинхэнэ албан хаагч, нээлттэй зарлуулсан 10 сул орон тооноос 1 буюу 10 хувь нь нөхөгдөөгүй.

Хууль тогтоомжийн хүрээнд төрийн захиргааны албан тушаал, зарим төрийн үйлчилгээний албан тушаалууд төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлд шилжсэнтэй холбогдуулан мэдээллийн технологийн болон санхүүгийн чиг үүрэг хэрэгжүүлдэг 16 албан хаагчийг тусгай шалгалтад хамруулах захиалгыг салбар зөвлөлийн 04 дүгээр сарын 29-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр хүргүүлсэн бөгөөд төрийн тусгай албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 06 дугаар сарын 19-ний өдрийн 24 дүгээр хуралдаанаар хэлэлцэж, 283, 284 дүгээр тогтоолоор зөвшөөрөл олгосон бөгөөд ирэх 07 дугаар сард багтаан тусгай шалгалтыг зохион байгуулахаар хүлээгдэж байна.

Хүснэгт-2

№	Тусгай шалгалт зохион байгуулсан огноо	Тоо		Сул орон тоог		Тайлбар
		Удирдах албан тушаал	Гүйцэтгэх албан тушаал	Нөхсөн	Нөхөөгүй	
1	2024.01.05		3	3	-	-
2	2024.02.14	1	2	3		-
3	2024.04.10	-	4	3	1	Бүртгүүлээгүй
	ДҮН	1	9	9	1	

Тухайн албан тушаалын буюу тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн hh-admin.csc.gov.mn цахим системээр зохион байгуулж, сонгон шалгаруулалтын захиалга, зар оруулах, бүртгэх, шалгалт авах, дүнг мэдээлэх бүх үйл явц цахимаар явагдаж хэвшсэн.

Гурав. Бусад үйл ажиллагааны талаар:

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланг Төрийн албаны тухай хуулийн 74.1 дэх хэсэг, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүргийн дагуу нэгтгэн, байгууллагын даргын 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01/36 албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газарт хугацаанд нь хүргүүлэв.

Салбар зөвлөлийн 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр хурлаар 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлж, салбар зөвлөлийн 05 дугаар тогтоолоор батлуулсан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганаар эцэслэн батлагдсан бөгөөд тухайн оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Уг хуулийн 41 дүгээр зүйлийн 41.20-д “Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажилласан нэг жилийг нэг жил гурван сар ажилласанд тооцох ...” гэж заасны дагуу байгууллагын албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо (ХНУМТ) цахим системд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэг жилийг нэг жил гурван сараар тооцогдохоор нэмэлт хөгжүүлэлт хийлгэх хүсэлтийг 02 дугаар сарын 16-ны өдрийн 01/357 албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлээд байна.

2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 41.2-т заасны дагуу албан хаагчид төрийн тусгай албан хаагчийн ангилалд багтаж, мөн хуулийн 41.14, 41.18-д Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэл, албан хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны, мэргэшлийн, эрдмийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийн хэмжээг Засгийн газраас тогтооно гэж заасны дагуу Төрийн албаны хууль тогтоомжид нийцүүлэн Монгол Улсын Засгийн газрын 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Журам батлах тухай” 160 дугаар тогтоолоор байгууллагын албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг шинээр батлуулсан.

Гадаадын иргэн, харьяатын газрын бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулах санал (стратегийн бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтцийн схем, орон тооны хуваарилалт, танилцуулга)-ыг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01/811 албан бичгээр хүргүүлсэн бөгөөд Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай Хууль зүй, дотоод хэргийн сайдын 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/129 дүгээр тушаал батлагдсан. Мөн байгууллагын даргын Гадаадын иргэн, харьяатын газрын төвийн зохион байгуулалтын нэгжүүдийн ажил, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай А/157, Гадаадын иргэн, харьяатын газрын хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай А/158 дугаар тушаалыг тус тус баталлаа.

Хууль тогтоомжийн хүрээнд төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн төрийн тусгай 252, төрийн үйлчилгээний 64, нийт 316 албан тушаалын орон тооноос буюу 79.7 хувь нь төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлд хамаарч, цалин хөлс, нэмэгдэл (онцгой нөхцөл, цол, төрийн алба хаасан хугацааны) дунджаар 64 орчим хувиар нэмэгдлээ.

Мөн холбогдох хууль тогтоомжийн дагуу "Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн тусгай албан хаагчид мэргэшлийн зэрэг тогтоох шалгуур үзүүлэлт, түүнийг олгох журам"-ыг шинээр байгууллагын даргын 06 дугаар сарын 24-ний өдрийн А/249 дүгээр тушаалаар батлуулж, шаардлага хангасан 177 албан хаагчид 10-20 хүртэл хувийн мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгож эхэллээ.

Хоолны нөхөх төлбөрийг тогтоохтой холбоотой хязгаарлалт, жишиг тогтоосон эрх зүйн акт одоогоор байхгүй, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-т "албан хаагчийн ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардал, өдрийн хоолны мөнгийг 2 жил тутам нэмэгдүүлнэ" гэж заасан, орон нутаг дахь нэгжийн хилийн боомтын алслагдсан байршилд хуваариар үүрэг гүйцэтгэдэг албан хаагчдын хувьд хоол, унааны нөхөх төлбөрөөс гадна хил хяналтын бусад байгууллагын адил хоолны зардалд санхүүжилт олгодоггүй зэрэг хэрэгцээ шаардлага, 2024 онд баталсан төсөв, орон тоо, цалин, урамшууллын зардлаас 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар хоолны нөхөх төлбөрийг 34,000, унааны нөхөх төлбөрийг 1,000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож, 04 дүгээр сарын 01-ний өдрөөс олгож эхэлсэн нь Төрийн албаны хууль тогтоомжийн хүрээнд албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад бодитой шинэчлэл боллоо.

Албан хаагчид төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлд шилжиж, хууль тогтоомжийн дагуу авах нэмэгдэл хөлсний төрөл нэмэгдсэн, хоол, унааны нөхөх төлбөрийг нэмснээр байгууллагын нийт албан хаагчдын 79.7 хувийн сарын цалин, хөлс 49-79 хүртэл хувиар өсөж, албан хаагчдыг хилийн боомт, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгаа сайжирснаар мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх боломж бүрдлээ.

Мөн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.20-д "хилийн боомт, орон нутаг дахь албанд таваас доошгүй жил ажиллаж байгаа албан хаагчид ажилласан таван жил тутам 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох" зохицуулалтын хамрах хүрээг өргөжүүлж, хилийн боомт, орон нутаг дахь нэгжид ажиллаж байгаа төрийн тусгай албан тушаалын орон тоонд ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг хамруулах болсон.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай" журамд заасан төрийн алба хаасан хугацаа, тухайн ангилалд ажилласан жил, 2023 оны ажлын гүйцэтгэлийн үнэлгээг харгалзан зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох шаардлага хангасан албан хаагчдын судалгааг боловсруулж, байгууллагын даргын 02 дугаар сарын 01-ний өдрийн 02/260 албан бичгээр төрийн захиргааны ахлах түшмэлд шинээр 1, ахиулах 3, дэс түшмэлд шинээр 3, ахиулах 32, нийт 39 албан хаагчид зэрэг дэв шинээр болон ахиулан олгуулах судалгааг нэгтгэж, салбарын сайдад хүргүүлсэн бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/115 дугаар тушаалаар ахлах түшмэлийн дөтгөөр 1, гутгаар 3, дэс түшмэлийн дөтгөөр 3, гутгаар 13, дэд 6, тэргүүн 13 нийт 39 албан хаагчийн зэрэг дэвийг шинэчлэн болон ахиулан тогтоолгож, нэмэгдлийг 04 дүгээр сарын 16-ны өдрөөс олгосон.

Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомжийн хүрээнд төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлд өмнө төрийн захиргааны ангилал, зэрэглэлд хамаарч байсан 220, төрийн үйлчилгээний ангиллаас төрийн тусгайд 26 албан тушаал шилжсэн, 6 орон тоо нэмэгдсэнтэй холбогдуулан удирдах, гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулж, батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгууллагын даргын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар байгуулж ажиллуулсан.

Уг ажлын хэсэгт төв байгууллагын газар, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, Захиргаа, удирдлагын газрын хүний нөөцийн мэргэжилтнүүд 252 төрийн тусгай албан тушаалд хамаарах удирдах 12, гүйцэтгэх 64 албан тушаалын тодорхойлолтын боловсруулалтыг хийж, Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газраар хянуулан өгсөн зөвлөмж, чиглэлийг тусгаж, Төрийн албаны зөвлөлийн 06 дугаар сарын 19-ний өдрийн 24 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн 283, 284 дүгээр тогтоолоор нийт 76 төрийн тусгай албан тушаалын тодорхойлолтод батлах зөвшөөрөл авлаа.

Тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөл болон холбогдох дээд шатны байгууллагад дараах мэдээ, судалгааг хүргүүлсэн. Үүнд:

Төрийн албаны хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулахаар ирүүлсэн Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам, Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам, Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх, нөөцийн сан ашиглах журам гэсэн 3 журмын төсөлд тусгах 22 саналыг Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 04 дүгээр сарын 18-ны өдрийн 03 дугаар албан бичгээр болон цахимаар Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газарт хүргүүлэв.

Мөн Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 105 дугаар тогтоолоор Төрийн албаны өдрийн жил бүрийн 07 дугаар сарын 03-ны өдөр байхаар “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийн жагсаалт”-д нэмэлт оруулж, баталсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн ажлын албанаас салбар зөвлөлүүдэд “Мэндчилгээ” ирүүлэх чиглэл ирүүлсний дагуу 3 төрлийн постер буюу зурагт мэндчилгээ хийж, 06 дугаар сарын 20-ны өдөр цахимаар хүргүүлээ.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛ**